



МОНГОЛ УЛСЫН
ХАРИУЦАА, ЭДИЙН ЗАСГИЙН
ТӨСЛӨ АЖИЛЛАГААНЫ ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Хангайн өргөн чөлөө 78, Утас: 25 21 55
Факс: (976-11) 52 21 27, E-mail: info@mfa.gov.mn
<http://www.mfa.gov.mn>

2014. 10. 22 № 09/30

Танай _____ -ны № _____

ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ, ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Б.ПҮРЭВДОРЖ ТАНАА

Улаанбаатар хотноо 2014 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр гарын үсэг зурсан "Монгол Улсын иргэд, Оросын Холбооны Улсын иргэд харилцан зорчих нөхцлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр", "Хууль бусаар байгаа иргэдийг буцаан шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр" болон түүнийг хэрэгжүүлэх журмын тухай гүйцэтгэх протокол нь 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс хүчин төгөлдөр болохыг үүгээр мэдэгдэж байна.


Хэлэлцээрийн хуулбарыг танай ажлын хэрэгцээнд зориулан үүгээр хүргүүлэв. Холбогдох газартаа уламжилна уу.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БОЛДБААТАР



08000000113



МОНГОЛ УЛСЫН ИРГЭД ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ИРГЭД
ХАРИЛЦАН ЗОРЧИХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар
(цаашид "талууд" гэх),

хоёр улсын найрсаг, сайн хөршийн харилцааг цаашид хөгжүүлэх хүсэл
эрмэлзлэлийг удирдлага болгон,

хоёр улсын иргэд харилцан зорчих нөхцөлийг хөгжөөгчх зорилгоор,

эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд үндэслэн,

дараахь зүйлийг тохиролцов:

1 дүгээр зүйл

1. Нэг Талын улсын иргэд нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт зорчих хугацаа
нь тасралтгүй 30 хоногтоос илүүгүй бол энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг болох
хавсралтад дурдсан, хувийн байдлыг тогтоох хүчин төгөлдөр бичиг баримт (цаашид
"хүчин төгөлдөр бичиг баримт" гэх)-аар энэхүү хэлэлцээрийн 6, 7 дугаар зүйлд
зааснаас бусад тохиолдолд визгүйгээр орж, гарч, дамжин өнгөрч, зорчих болно.
Чингэхдээ нэг Талын улсын иргэний нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт визгүй
зорчих нийлбэр хугацаа түүний анх орсон өдрөөс эхлэн 180 хоногийн туршид 90
хоногтоос илүүгүй байна.

2. Нэг Талын улсын нутаг дэвсгэрт 30 хоногтоос дээш хугацаагаар зорчих,
эсхүл оршин суух, эсхүл тухайн улсын нутаг дэвсгэрт хөдөлмөр буюу ажилмааны
үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй нөгөө Талын улсын иргэд орох гэж буй улсын хууль
тогтоомжийн дагуу виз авах ёстой.

2 дугаар зүйл

1. Талууд хүчин төгөлдөр бичиг баримтын загварыг энэхүү хэлэлцээрт гарын
усаг зурсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дипломат шугамаар солилцоно.

2. Дотоодын хууль тогтоомж болон хүчин төгөлдөр бичиг баримтад өөрчлөлт
орох, эсхүл шинэ бичиг баримт хэрэглэх тохиолдолд талууд энэ тухай бие биедээ
нэн даруй мэдэгдэх бөгөөд шинэ буюу өөрчлөгдсөн хүчин төгөлдөр бичиг баримтын
загварыг шинэ бичиг баримтыг хэрэглэж эхлэх буюу хүчин төгөлдөр бичиг баримтад
орсон өөрчлөлт үйлчилж эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө нөгөө Талдаа
дипломат шугамаар өгнө.

3 дугаар зүйл

Нэг Талын улсын насанд хүрээгүй иргэд өөрсдийн хүчин төгөлдөр бичиг
баримтаар, эсхүл хэрэв Тал тус бүрийн улсын хууль тогтоомжийн дагуу насанд
хүрээгүй иргэд эцэг, эхийн хүчин төгөлдөр бичиг баримтад бичигдсэн бол тэднийг
далгадан яваа эцэг, эхийн хүчин төгөлдөр эцгээр бичиг баримтад үндэслэн нөгөө
Талын улсын нутаг дэвсгэрт орж, гарч, дамжин өнгөрч, зорчихо.

4 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрт заасны дагуу нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт орж буй
нэг Талын улсын иргэд нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт зорчих хугацаандаа
тухайн орсон улсын хууль, журмыг сахин мөрдөх үүрэгтэй.

5 дугаар зүйл

Нэг Талын улсын иргэд нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт орох, нутаг
дэвсгэрээс нь тарахдаа Тал тус бүрийн улсын хууль тогтоомжийн дагуу нээсэн
хилийн боомтоор нэвтэрнэ.

6 дугаар зүйл

Нэг Талын улсын нутаг дэвсгэрт оршиж байгаа дипломат төлөөлөгчийн газар,
консулын байгууллага, эсхүл олон улсын байгууллагын дэргэдэх төлөөлөгчийн
газарт ажиллахаар томилогдсон нөгөө Талын улсын иргэд, түүнчлэн тэдэнтэй хамт
амьдардаг дипломат, эсхүл албан паспорттай гэр бүлийн гишүүд (эхнэр, нөхөр,
насанд хүрээгүй хүүхэд болон асрамжид нь байдаг бусад хүн) тухайн иргэдийн
томилолтоор ажиллах бүх хугацааны туршид тухайн улсын нутаг дэвсгэрт
визгүйгээр орох, гарч, дамжин өнгөрөх, зорчих эрхтэй.

7 дугаар зүйл

Нэг Талын улсын нутаг дэвсгэрт түр оршин суух зөвшөөрөлтэй нөгөө Талын
улсын иргэд тухайн улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр бичиг баримтаар
визгүйгээр орж, гарч, зорчих болно.

8 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээр нь аль нэг Талын улсын эрх бүхий байгууллага нөгөө Талын улсын иргэдийг тухайн улсын нутаг дэвсгэрт оруулах, эсхүл зорчуулахаас өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу татгалзах эрхийг хязгаарлахгүй.

9 дүгээр зүйл

1. Нэг Талын улсын иргэд нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт зорчих хугацаандаа хүчин төгөлдөр бичиг баримтаа, үргэлдүүлсэн, эсхүл гэмтээсэн тохиолдолд өөрийн иргэний харьяалалтай улсын дипломат төлөөлөгчийн газар эсхүл консулын байгууллагаас шинээр олгосон хүчин төгөлдөр бичиг баримтаар визгүй, эсхүл зорчиж буй улсын эрх бүхий байгууллагын өөр бусад зөвшөөрөлгүйгээр тухайн улсын нутаг дэвсгэртээ гарна.

2. Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд нөгөө Талын улсын нутаг дэвсгэртээ урьдчилан тооцоогүй шалтгаан (өвчлөх, байгалийн гамшиг тохиолдох гэх мэт)-аар гарах боломжийг болсон нэг Талын улсын иргэд уг шалтгааныг нотолсон бичиг баримттай бол өөрийн иргэний харьяалалтай улс, эсхүл байнга оршин суугаа улсаа буцахад шаардлагатай хугацааг тухайн улсын нутаг дэвсгэрт зорчих хугацааг сунгуулах хүсэлтээ эрх бүхий байгууллагад гаргаж болно.

10 дүгээр зүйл

1. Талуудын хоорондын харилцаанд үүссэн болон энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх, эсхүл тайлбарлахтай холбогдон гарсан маргаантай бүх асуудлыг зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

2. Зөвлөлдөх болон хэлэлцээ хийх журмыг Талууд тохиролцож тодорхойлно.

11 дүгээр зүйл

1. Тал тус бүр улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болно. Түдгэлзүүлэх тухай мэдэгдлийг нөгөө Талдаа ийнхүү түдгэлзүүлэхээс 48 цагаас багатуу хугацааны өмнө дипломат шугамаар бичгээр илгээнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шалтгаанаар энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг түдгэлзүүлэх шийдвэр гаргасан Тал нь энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг сэргээх тухайгаа нөгөө Талдаа мөн адил журмаар мэдэгдэнэ.

12 дугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээрийг тодорхой бүс хугацаагаар байгуулав. Хэрэв аль нэг Тал нь энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоохоор шийдвэрлэсэн бол энэ

тухайгаа нөгөө Талдаа дипломат шугамаар бичгээр мэдэгдэнэ. Энэхүү хэлэлцээрийн үйлчлэл нь дүрсэн мэдэгдлийг нөгөө Тал хүлээн авсан өдрөөс хойш 90 хоногийн дараа зогсоно.

2. Энэхүү хэлэлцээр нь Талууд түүнийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын журмаа биелүүлсэн тухай бичгээр өрсөн сүүлийн мэдэгдлийг дипломат шугамаар хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү хэлэлцээрт Талууд тохиролцож өөрчлөлт оруулж болно. Өөрчлөлт нь энэ зүйлийн 2 дэх хэсэгт заасан журмын дагуу хүчин төгөлдөр болно.

4. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 1995 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр гарын үсэг зурсан "Иргэд харилцан зорчих нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр" үйлчлэхээ болно.

Энэхүү хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 2014 оны 9 дүгээр сарын ...-ны өдөр Монгол, орос хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ
ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



Монгол Улсын иргэд, Оросын Холбооны Улсын
иргэд харилцан зорчих нөхцөлийн тухай Монгол
Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын
Засгийн газар хоорондын хэлэлцээрийн
хавсралт

Монгол Улсын иргэд, Оросын Холбооны Улсын иргэд харилцан зорчиход
шаардлагатай, иргэдийн хувийн байдлыг тогтоох хүчин төгөлдөр бичиг
баримтын жагсаалт:

1. Оросын Холбооны Улсад зорчих буй Монгол Улсын иргэдийн хувийн
байдлыг тогтоох хүчин төгөлдөр бичиг баримтад дараахь хамаарна:
 - а) үндэсний ангийн гадаад паспорт,
 - б) дипломат паспорт,
 - в) албан паспорт,
 - г) Монгол Улсад орох (буцах) үнэмлэх.
2. Монгол Улсад зорчих буй Оросын Холбооны Улсын иргэдийн хувийн
байдлыг тогтоох хүчин төгөлдөр бичиг баримтад дараахь хамаарна:
 - а) Оросын Холбооны Улсын иргэд дэвсгэрийн галцаа байгаа иргэдийг Оросын
Холбооны Улсын иргэн болохыг нотолсон Оросын Холбооны Улсын иргэний
паспорт,
 - б) дипломат паспорт,
 - в) албан паспорт,
 - г) Оросын Холбооны Улсад орох (буцах) үнэмлэх.

...



СОГЛАШЕНИЕ МЕЖДУ ПРАВИТЕЛЬСТВОМ МОНГОЛИИ И ПРАВИТЕЛЬСТВОМ РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ ОБ УСЛОВИЯХ ВЗАИМНЫХ ПОЕЗДОК ГРАЖДАН МОНГОЛИИ И ГРАЖДАН РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ

Правительство Монголии и Правительство Российской Федерации, далее
именуемые Сторонами,

руководствуясь желанием дальнейшего развития дружественных
и добрососедских отношений между двумя государствами,

стремясь упростить порядок взаимных поездок граждан своих государств,

основываясь на принципах равноправия и взаимной выгоды

согласились о нижеследующем.

Статья 1

1. Граждане государства одной Стороны выезжают, выезжают, следуют
транзитом и пребывают на территории государства другой Стороны на основании
действительных документов, удостоверяющих личность, указанных в Приложении к
настоящему Соглашению, являющейся его неотъемлемой частью (далее -
действительные документы). Без виз при условии, что продолжительность их
непрерывного пребывания на территории этого государства не превышает 30 дней,
за исключением случаев, предусмотренных статьями 6 и 7 настоящего
Соглашения. При этом суммарный срок пребывания граждан государства одной
Стороны на территории государства другой Стороны без виз не должен превышать
90 дней в течение периода в 180 дней начиная с даты первого въезда.

2. Граждане государства одной Стороны, намеревающиеся пребывать либо
проживать на территории государства другой Стороны более 30 дней либо
осуществлять трудовую или коммерческую деятельность на его территории,
должны получить визу в соответствии с законодательством государства въезда.

Статья 2

1. Стороны в течение 30 дней с даты подписания настоящего Соглашения обмениваются по дипломатическим каналам образцами действительных документов.

2. В случае внесения изменений в национальное законодательство и в действительные документы или введения новых документов Стороны незамедлительно информируют друг друга об этом и передают по дипломатическим каналам образцы новых или измененных действительных документов не позднее чем за 30 дней до их введения в действие или вступления в силу изменений.

Статья 3

Несовершеннолетние граждане государства одной Стороны выезжают, выезжают, следуют транзитом и пребывают на территории государства другой Стороны на основании действительных документов этих граждан или действительных документов сопровождающих их родителей, если в соответствии с законодательством каждой из Сторон несовершеннолетние граждане, вписаны в эти действительные документы родителей.

Статья 4

Граждане государства одной Стороны, которые выезжают на территорию государства другой Стороны в соответствии с настоящим Соглашением, пребывая на территории государства другой Стороны, обязаны соблюдать законы и правила государства въезда.

Статья 5

Граждане государства одной Стороны выезжают и выезжают с территории государства другой Стороны через пункты пропуска, открытые в соответствии с законодательством государства каждой из Сторон.

Статья 6

Граждане государства одной Стороны, направляемые на работу в его дипломатическое представительство, консульские учреждения или представительства при международных организациях, находящиеся на территории государства другой Стороны, а также проживающие вместе с ними члены их семей (супруг, супруга, несовершеннолетние дети и другие лица, находящиеся на их иждивении), имеющие дипломатические или служебные паспорта, выезжают, следуют транзитом и пребывают на территории этого государства без виз в течение всего срока аккредитации указанных граждан.

Статья 7

Граждане государства одной Стороны, имеющие разрешение на временное проживание на территории государства другой Стороны, выезжают, выезжают и пребывают на территории этого государства по действительным документам без виз.

Статья 8

Настоящее Соглашение не ограничивает права компетентных органов государства одной Стороны отказать во въезде или пребывании гражданам государства другой Стороны в соответствии с законодательством государства каждой из Сторон.

Статья 9

1. Граждане государства одной Стороны в случае утраты или порчи действительных документов во время пребывания на территории государства другой Стороны выезжают с территории этого государства на основании новых действительных документов, выданных дипломатическим представительством или консульским учреждением государства, гражданами которого они являются, без виз либо иных разрешений компетентных органов государства пребывания.

2. Граждане государства одной Стороны, не имеющие возможности выехать с территории государства другой Стороны в сроки, указанные в пункте 1 статьи 1 настоящего Соглашения, по причинам непредвиденного характера (заболевание, стихийное бедствие и др.), при наличии документально подтвержденных таких причин могут обратиться в компетентные органы за разрешением на продление пребывания на территории этого государства на период времени, необходимый для возвращения в государство своего гражданства или в государство постоянного проживания.

Статья 10

1. Все спорные вопросы, возникающие между Сторонами и связанные с реализацией или толкованием настоящего Соглашения, решаются путем консультаций между ними.

2. Порядок осуществления консультаций и переговоров определяется по договоренности Сторон.

Статья 11

1. Каждая из Сторон может в целях обеспечения государственной безопасности, охраны общественного порядка и здоровья населения приостановить применение настоящего Соглашения полностью или частично. Письменное уведомление о таком приостановлении направляется по дипломатическим каналам другой Стороне не позднее чем за 48 часов до приостановления.

2. Сторона, принимавшая решение о приостановлении применения настоящего Соглашения по причинам, указанным в пункте 1 настоящей статьи, в том же порядке уведомляет другую Сторону о возобновлении применения настоящего Соглашения.

Статья 12

1. Настоящее Соглашение заключается на неопределенный срок. В случае если одна из Сторон решит прекратить действие настоящего Соглашения, она в письменной форме уведомит об этом по дипломатическим каналам другую Сторону. Действие настоящего Соглашения прекращается через 90 дней с даты получения другой Стороной указанного уведомления.

2. Настоящее Соглашение вступает в силу по истечении 30 дней с даты получения по дипломатическим каналам последнего письменного уведомления о выполнении Сторонами внутренних государственных процедур, необходимых для его вступления в силу.

3. В настоящее Соглашение могут быть внесены изменения по взаимному согласию Сторон. Такие изменения вступают в силу в порядке, предусмотренном пунктом 2 настоящей статьи.

4. С даты вступления в силу настоящего Соглашения прекращает действовать Соглашение между Правительством Монголии и Правительством Российской Федерации об условиях взаимных поездок граждан, подписанное 5 апреля 1995 г.

Свершено в г. Улан-Баторе « 5 сентября 2014 г. в двух экземплярах, каждый на монгольском и русском языках, причем оба текста имеют одинаковую силу.

ЗА ПРАВИТЕЛЬСТВО
МОНГОЛИИ



ЗА ПРАВИТЕЛЬСТВО
РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ



Приложение
к Соглашению между
Правительством Монголии и Правительством
Российской Федерации
об условиях взаимных поездок граждан
Монголии и граждан Российской Федерации

ПЕРЕЧЕНЬ

действительных документов, удостоверяющих личность, необходимых при осуществлении взаимных поездок граждан Монголии и граждан Российской Федерации

1. Для граждан Монголии действительными документами, удостоверяющими личность при осуществлении поездок в Российскую Федерацию, являются:

- а) национальный заграничный паспорт;
- б) дипломатический паспорт;
- в) служебный паспорт;
- г) свидетельство на въезд (возвращение) в Монголию.

2. Для граждан Российской Федерации действительными документами, удостоверяющими личность при осуществлении поездок в Монголию, являются:

- а) паспорт гражданина Российской Федерации, удостоверяющий личность гражданина Российской Федерации за пределами территории Российской Федерации;
- б) дипломатический паспорт;
- в) служебный паспорт;
- г) свидетельство на въезд (возвращение) в Российскую Федерацию.